

Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны  
02 сарын 14-ний өдрийн BR 24/005  
дугаар тогтоолын хавсралт №3



**ТЭНГЭР ДААТГАЛ ХХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО, ЖУРАМ**

Домэйн:	ТУЗ
Эзэмшигч:	ТУЗ
Баримт бичиг баталсан:	Гүйцэтгэх удирдлагын хороо
Хувилбар #:	
Хүчинтэй хугацаа:	2024.01.24
Шийдвэр # (хэрэв байгаа бол)	

## ЗАСВАРЫН ТҮҮХ

Доорх Засварын Түүхийн хүснэгтэд энэхүү баримт бичиг хэрэглэгдэж буй хугацаанд орсон бүх засварыг тэмдэглэнэ. Шинэчлэлтийг хийсэн огноо, хувилбарын дугаар, хийгдсэн өөрчлөлтүүдийн тайлбар, шалтгааны товч тайлбар, шинэчилсэн болон баталсан хүний нэр зэргийг хянах.

Хүчинтэй хугацаа	Шийдвэр # (хэрэв байгаа бол)	Хувилбар #	Өөрчлөлт Тайлбар / Шалтгаан	Үүсгэсэн / шинэчилсэн	Батлагдсан
2022.07.02		1.0	Нэг дэх хувилбар		ТУЗ-ын BR22/19
2024.01.24		2.0	2 дахь хувилбар	Б.Энхтүвшин	

## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО .....	3
ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ШИЙДВЭР .....	3
ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ .....	4

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү ногдол ашгийн бодлого, журам нь Тэнгэр Даатгал ХХК-ын хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн бодлогыг тодорхойлох, түүнийг хуваарилах, ногдол ашгийн хэмжээ, хуваарилах нөхцөлийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Даатгалын тухай хууль, Компанийн тухай хууль, компанийн дүрэмийн хүрээнд төлөөлөн удирдах зөвлөлөөс энэхүү бодлого, журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөгө болгоно.

## ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1. Энэхүү ногдол ашгийн бодлого нь Даатгалын тухай хууль заасан шаардлага, компанийн дүрэм, үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.
- 2.2. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйл, Даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйл, энэхүү бодлого, журмын 3 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд тухайн тайлангийн хугацаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг татвар төлсний дараах цэвэр ашгаас, компанийн богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулан тогтоох бөгөөд жил бүр ногдол ашиг хуваарилах бодлого баримтална.
- 2.3. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилах.
- 2.4. Хуваарилсан ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгох бөгөөд энэхүү мөнгөн дүнд нийцүүлэн эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

## ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ШИЙДВЭР

- 3.1. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.
- 3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчидэд заавал тайлбарлана.
- 3.3. Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.4. Улирлын санхүүгийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилах эсэхийг энэхүү бодлого, журмын 2.2-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэж болно.
- 3.5. Ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна:
  - 3.5.1. Хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
  - 3.5.2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
  - 3.5.3. Ногдол ашиг төлөх өдөр буюу олгож эхлэх, дуусан хугацаа;
  - 3.5.4. Ногдол ашиг олгох зам, хэлбэр

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ

- 4.1. Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.
- 4.2. Ногдол ашиг хуваарилалтын тайланг тогтоосон журмын дагуу зохицуулах байгууллагуудад хүргүүлнэ.
- 4.3. Ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.